

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 6, 14 дэх заалт нэмсүгэй:

“6/ Эдийн засаг, хөгжлийн яам;”

“14/ Цахим хөгжил, харилцаа холбооны яам;”

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 6, 7, 8, 9, 10, 11, 12 дахь заалтын дугаарыг “7, 8, 9, 10, 11, 12, 13” гэж, 13, 14 дэх заалтын дугаарыг “15, 16” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд доор дурдсан агуулгатай 9, 17 дахь заалт нэмсүгэй:

“9/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эдийн засаг, хөгжлийн сайд;”

“17/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Цахим хөгжил, харилцаа холбооны сайд;”

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 9, 10, 11, 12, 13, 14, 15 дахь заалтын дугаарыг “10, 11, 12, 13, 14, 15, 16” гэж, 16, 17 дахь заалтын дугаарыг “18, 19” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ